



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 126

Мандалговь

Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 218,840,729.11 /хоёр зуун арван найман сая найман зуун дөчин мянга долоон зуун хорин есөн төгрөг арван нэгэн мөнгө/ төгрөгийн балансын үнэтэй, 193,005,365.35 /нэг зуун ерэн гурван сая таван мянга гурван зуун жаран таван төгрөг гучин таван мөнгө/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хуучин МСҮТ-ийн дотуур байрын барилгыг Сайнцагаан сумын Цэгц билиг сургуулийн үндсэн хөрөнгөд балансаас балансад шилжүүлсүгэй.

Хоёр: Сайнцагаан сумын Засаг даргын тамгын газрын дарга /Ц.Лхагвасүрэн/, Цэгц билиг сургуулийн захирал /Б.Түвшин-Эрдэнэ/ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

- 2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг сум болон байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;
- 2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;
- 2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын  
24-ний өдрийн 126 дугаар тогтоолын хавсралт

Сайнцагаан сумын ЗДТГ-ын балансаас балансад шилжүүлэх барилгын мэдээлэл

| д/д                  | Хөрөнгийн нэр    | Зориулалт   | Хүчин чадал |             | Ашиглалтад орсон огноо | Ашиглалтын нийт хугацаа /жилээр/ | Балансын үнэ  | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг |
|----------------------|------------------|-------------|-------------|-------------|------------------------|----------------------------------|---|-----------------------|----------------|
|                      |                  |             | Хэмжих нэгж | Биет хэмжээ |                        |                                  |   |                       |                |
| 1                    | МСҮТ дотуур байр | Дотуур байр |             |             | 1997.01.01             | 24                               | 218,840,729.11  | 25,835,363.76         | 193,005,365.35 |
| <b>Хөрөнгийн дүн</b> |                  |             |             |             |                        |                                  |   |                       |                |
|                      |                  |             |             |             |                        |                                  | <b>218,840,729.11</b>   |                       |                |
|                      |                  |             |             |             |                        |                                  | <b>/хоёр зуун арван найман сая найман зуун дөчин мянга долоон зуун хорин есөн төгрөг арван нэгэн мөнгө/</b> |                       |                |